

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны ... сарын ... өдөр

Дугаар А/.....

Улаанбаатар хот

## Журам батлах тухай

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 55.5 дахь хэсэг, 2711 дүгээр зүйлийн 2711.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гаалийн ерөнхий газрын даргын “Заавар батлах тухай” 2016 оны А/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ын

1.1-д /CEPS гэх/ гэсний оронд /cps.gaali.mn, gaali.mn/ гэж өөрчлөх;

1.3-ыг “Гаалийн мэдүүлэг нь үндсэн ба нэмэлт мэдүүлгээс бүрдэнэ. Нэмэлт мэдүүлэг нь үндсэн мэдүүлгийн салшгүй нэг хэсэг байна. Гаалийн мэдүүлэг нь 10-энгийн, 20-багц, 30-урьдчилж мэдүүлэх, 40-ТИР, 50-цаасгүй бүрдүүлэлт /эрдэс бүтээгдэхүүнээс бусад/, 70-хялбарчилсан бүрдүүлэлт, 80-нууцад хамаарах, 90-эрдэс бүтээгдэхүүн гэсэн төрөлтэй байна.” гэж өөрчлөн найруулах;

1.7.1.-д “бараа илгээх, эсхүл хүлээн авах Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага өөрөө,” гэснийг “бараа илгээх, эсхүл хүлээн авах Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага өөрөө цахимаар мэдүүлэх” гэж өөрчлөн найруулах;

зааврын

1.25-д “...мэдээллийн сүлжээгээр ирүүлж болно.” гэсний ард “Мэдүүлгийн маягтын 52 дугаар хүснэгтийн дагалдах бичиг баримтуудыг програмд оруулах бол бичиг баримтын төрлийг сонгож, бичиг баримтын дугаар, огноог нөхөж бичих ба гадаад худалдааны бичиг баримтыг зөвхөн файл хэлбэрээр .pdf форматаар хавсаргана.”

БТКУС-ын 8701-8705 кодоод хамаарах тээврийн хэрэгслийг Автомашины мэдүүлэг цэсээр мэдүүлнэ. гэж нэмэх;

зааврын 1.31-ийг “Мэдүүлэгч нь сүлжээгээр нөхөн бичсэн гаалийн мэдүүлгийг “хянах” товч дарж шалгасны дараа “илгээх” товчийг дарж Гаалийн автоматжуулсан системд /CAIS/ илгээнэ. Гаалийн мэдүүлэг “хүлээн авсан” төлөвт шилжсэн бол гаалийн байгууллагад мэдүүлсэнд тооцно.” гэж өөрчлөн найруулах;

1.32-ийг “ нөхөн бичсэн боловч гаалийн байгууллагад илгээгээгүй сүлжээнд хадгалагдаж байгаа мэдүүлгийг шаардлагатай тохиолдолд устгаж болно.” гэж өөрчлөн найруулах;

**1.-д шинээр нэмэх:**

Зааврын хоёр дахь хэсэг. Гаалийн мэдүүлгийн нөхөн бичих хүснэгтэд байгаа мэдээлэлд Нэгдүгээр хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулах;

2. Гаалийн ерөнхий газрын даргын “Заавар батлах тухай” 2016 оны А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-ын
  - 2.4. Улбар шар болон улаан төлөв сонгогдсон тохиолдолд бичиг баримтын шалгалт хийхээр томилогдсон гаалийн улсын байцаагч гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг шалгана. Цахимаар өөрөө мэдүүлж байгаа бол CAIS програмд гадаад худалдааны бичиг баримтыг цахим гарын үсгээр баталгаажуулан файлаар оруулах ба эх хувийн нэгэн адил тооцогдоно гэж нэмэх,
  - 2.7.-гийн Мэдүүлэгч нь Гаалийн тухай хуулийн 60.3.1-60.3.5 дахь заалт, 75.1 дэх хэсэгт заасан бичиг баримтыг цахим гарын үсгээр баталгаажуулж гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд мэдээллийн сүлжээгээр ирүүлсэн бол эх хувийн нэгэн адилд тооцогдоно. Шаардлагатай тохиолдолд эх хувьтай нь тулган шалгаж болно гэж өөрчлөн найруулах.
  - 2.13. Улаан төлөв сонгогдсон мэдүүлэг татвар төлсөн төлөвт орсны дараа мэдүүлгийн бичлэг хяналт шалгалт хийх гаалийн улсын байцаагчид шилжинэ.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн бүрдүүлэлтийн газар /Д.Зоригго/, Статистикийн хэлтэс /Э.Лхагвасүрэн/, Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д тус тус даалгасугай.

Гаалийн ерөнхий газрын даргын ... тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт

**Хоёр. Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих**

Хүснэгт	Хүснэгтийн нэр	Тайлбар
1	Бүрдүүлэлтийн горим	Нэгдүгээр хүснэгтийн арын хэсэгт бүрдүүлэлтийн горимын кодыг бичих бөгөөд хүснэгтийн эхний хэсэгт тухайн барааг гаалийн хилээр нэвтрүүлж байгаа ялгаанаас хамааран: -гаалийн хилээр оруулах барааг – “ОР” -гаалийн хилээр гаргах барааг – “ГА” -барааг шилжүүлэн ачих бол – “ШИ” -барааг устгахад – “УС” -барааг хүлээн авахаас татгалзах – “ТА” гэсэн 2 үсэгт тэмдэглэгээг системээс тодорхойлсон төрлүүдээс сонгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг <a href="https://gaali.mn/categories/procedure">https://gaali.mn/categories/procedure</a> холбоосоор авах гэж нэмэх
4	Хүлээн авагч	Бараа хүлээн авагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэний регистрийн дугаарыг бичихэд хүлээн авагчийн мэдээлэл системээс автоматаар бөглөгдөнө гэж нэмэх. Утасны дугаарыг гараас оруулна.
5	Санхүүгийн хувьд хариуцагч	Гадаад худалдааны төлбөр тооцоо хийсэн санхүүгийн хувьд хариуцагчийн регистр №, нэр, банкны нэр, дансны дугаар, хаягийн мэдээллийг оруулна. Санхүүгийн хувьд хариуцагч нь мэдүүлэгч өөрөө бол тэмдэглэснээр тухайн хэрэглэгчийн мэдээлэл системээс автоматаар бөглөгдөнө гэж нэмэх
7	Бараа нийлүүлэх суурь нөхцөл	Хилийн боомт хэсэгт барааны хил нэвтэрсэн боомтын нэрийг сонгоно.
8	Хэлцэл	Хэлцлийн ерөнхий дүн - Үнийн нэхэмжлэхийн үнийн дүн буюу тухайн ачилтад хамрагдах бүх барааны нийт үнийн дүнг өмнө сонгосон валютаар илэрхийлж бичнэ. Жишээ нь: Гэрээнд 119 тонн цагаан будааг 1 тонныг нь 600 ам.долларын үнээр худалдан авахаар гэрээ байгуулсан ба барааны нийт үнийн дүн 71400 ам.доллар байна. Энэ тохиолдолд хэлцлийн ерөнхий дүн дээр 71400 гэсэн тоо утгыг оруулна Төлөлтийн код - Тухайн барааны татварын төлөлтийг ямар аргаар хийж байгааг сангаас сонгоно. Жишээ нь: Бэлэн мөнгө тушаасан-101, Бэлэн бусаар тушаасан -201, Урьдчилсан төлбөрөөс суутгал хийсэн-301 гэх мэт. Хэлцлийн код – хэлцэл хийсэн онцлог тохирсон худалдааны төрлийг кодолсон. Жишээ нь валютын төлбөртэй бараа г.м Төлөлтийн код – хэлцлийн төлбөрийг хэрхэн төлсөн төрлийг заасан код. Жишээ нь 110 – валютын төлбөртэй бараа. нэмэх

23	Барааны код	<p>БТКУС (барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем) буюу Барааны ангиллын кодыг Уялдуулсан системийн дагуу заавал 8 оронтой ангиллын кодыг сангаас сонгож оруулна. Барааны нэр болон кодоор хайлт хийж ангиллын кодыг сонгох боломжтой. БТКУС-тай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг <a href="https://gaali.mn/hscod/mn">https://gaali.mn/hscod/mn</a> холбоосоор авах боломжтой. Гэж өөрчлөх</p> <p>Автомашин мэдүүлэг нөхөн бичих үед БТКУС-ын 87.01-87.05 кодоод хамаарах тээврийн хэрэгслийн /төрөл, хөдөлгүүрийн төрөл, хөдөлгүүрийн багтаамж, үйлдвэрлэсэн он, бүх жин/ мэдээллийг системд оруулахад барааны код автоматаар тодорхойлогдоно.</p>
24	Гарал үүслийн улс	<p>Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн гарал үүслийн улсын нэрийг сонгож оруулна.</p> <p>Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг үндэслэн тарифын төрлийг сонгож оруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэн тааламжтай тариф: - ДХБ-ын гишүүн орнууд болон Беларусь Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. Гарал үүслийг нотлох баримт хавсаргасан байна.</li> <li>- Ердийн тариф: - Гарал үүслийг нотлоогүй тохиолдолд ердийн тарифыг хэрэглэнэ. Нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. - Хөнгөлөлттэй тариф: - Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу Япон Улсын гарал үүсэлтэй бараанд хэрэглэнэ. ЭЗТХ-ийн гарал үүслийн гэрчилгээ хавсаргана гэж өөрчлөх</li> </ul>
20	Ханш	<p>Гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 19 дүгээр хүснэгтэд бичигдсэн валютын төгрөгтэй харьцах Монгол банкнаас тогтоосон ханш шууд тооцогдоно.</p>
21	Барааны нэр, төрөл	<ul style="list-style-type: none"> <li>- БТКУС-ийн 87.01-87.03-д кодоод хамаарах тээврийн хэрэгслийн хувьд барааны бичиглэлийн талбарт мэдээллийг дараах байдлаар бичнэ гэж өөрчилөх.</li> <li>- Гэрээний дугаар талбарт Татварын ерөнхий газарт бүртгүүлж Гэрээ бүртгэлийн програмд оруулсан ашигт малтмалтын бүтээгдэхүүний гадаад худалдаатай холбоотой гэрээг гэрээний дугаарыг татаж оруулна гэж нэмэх.</li> <li>- Лабораторийн дүгнэлт хэсэгт ГТЛ-ийн дүгнэлттэй барааны дүгнэлтийн дугаараар хайлт хийн татахад барааны онцлог шинж автоматаар бөглөгдөнө.</li> </ul>